

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хүүхдийн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, хүүхдийг үл хайхрах, хүүхэдтэй зүй бусаар харьцах, мөлжлөгийн аливаа хэлбэрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар тусгасан байна

Хуулийн төсөл батлагдсанаар хүүхдийн эрх баталгаажиж, хүүхэд хамгааллын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой гэж үзжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хүүхдийн эрхийг хамгаалах лобби бүлэг байгуулах тухайгаа дурдаад хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх асуудлыг илүү тусгах, өвлийн цагт хүүхдээр хурдны морь унуулахыг хориглох, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр хуулийн зарим заалтын эдийн засгийн үр дагаврыг тооцоолох, төрийн байгууллагын эрх, үүргийг оновчтой тодорхойлох, төслийн зарим тунхаглалын шинжтэй заалт, үг хэллэг, найруулгыг засах, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл төрийн байгууллагын эрх, үүрэг, хүүхдийн журамт үүргийг эргэн харах, хуулийн зарим нэр томъёо, шинэ ойлголтыг оновчтой тодорхойлох, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан хүүхдэд аюулгүй, ээлтэй орчинг бүрдүүлэх, хүүхдийг бие дааж амьдрах чадвартай болгох зэрэг саналуудыг тус тус гаргалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Д.БАТЦОГТ

